



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 25-ны өдөр

Дугаар 1/58

Эрдэнэт

“Үнэлгээний хороо байгуулах тухай”

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 6-23 сартай хүүхэд, хөхүүл эх, жирэмсэн эмэгтэйчүүдийн олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл, жирэмслэлтээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог хавсралтаар баталсугай.
2. Тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, ажлын явцыг Эрүүл мэндийн газрын даргад танилцуулахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын  
2021 оны 05.-р сарын 25.-ны өдрийн  
118.. дугаар тушаалын хавсралт

## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга: - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эм зүйн албаны дарга Н.Амаржаргал

Гишүүд: - АЗДТГ-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Даваадорж /Зөвшилцсөнөөр/  
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батжаргал  
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн төлөөлөн /Жаргалант сумын ЭМТ-ийн эх баригч-бага эмч Х.Нарантуяа/

Нарийн бичгийн дарга: -Эрүүл мэндийн газрын Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн О.Анхбаяр